

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ
ОРШИХ “МАК ЦЕМЕНТ” ХХК-ИЙН ХӨХ ЦАВЫН ЦЕМЕНТ ШОХОЙН
ҮЙЛДВЭР ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5830974

ХҮЛЭЭН АВСАН:

ДОРНОГОВЬ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР УУЛ УУРХАЙН ҮНЭЛГЭЭ, НӨХӨН
СЭРГЭЭЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Х.ЭРДЭМТӨГС

ТАНИЛЦСАН:

ҮЙЛДВЭРИЙН ДАРГА



Б.БАТЖАРГАЛ

ХЯНАСАН:

БАЙГАЛЬ ОРЧИН ТОГТВОРТОЙ
ХӨГЖЛИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН *Э. Батсайхан*

Э. БАТСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН:

БАЙГАЛЬ ОРЧИН ТОГТВОРТОЙ
ХӨГЖЛИЙН МЭРГЭЖИЛТЭН

Г.УУГАНБАТ -г

2025 ОН

ГАРЧИГ

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	5
ҮЙЛДВЭРИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	13
ЦЕМЕНТ ШОХОЙН ҮЙЛДВЭРИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ, ҮНДСЭН ҮР ДҮН	14
1.СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	16
2.ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 33	
3.НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	35
4. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	35
5. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..	35
6.ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	40
7. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	49
8.УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	60
9.ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..	66
10.БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ АЖЛЫН НИЙТ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ..	68
ДҮГНЭЛТ	69
ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТУУД.....	70
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	
Зураг 1. Үйлдвэрийн байршил	6
Зураг 2. Ерөнхий төлөвлөлтийн зураг	7
Зураг 3. Технологийн схем	11
Зураг 4. Цемент үйлдвэрлэл, 2025.01-09 сар	12
Зураг 5. Цемент борлуулалт	12
Зураг 6. Агаарын чанарт үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	13
Зураг 7. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	13
Зураг 8. Усны чанарт үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд.....	14
Зураг 9. Ургамлан нөмрөг, амьтны аймагт үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	14
Зураг 10. Зам талбайн усалгаа хийж буй байдал	19
Зураг 11. Хурд хэтрүүлэлтийн тайлан мэдээ	20
Зураг 12.Ханцуйт шүүлтүүрийн байрлал.....	21
Зураг 13. “Чандмань Илч”ХХК тоолуур суурилуулж буй байдал 2025.04 сар.....	22
Зураг 14. Худгийн тоолуур салгасан акт 2025.10.09.....	22
Зураг 15. Үйлдвэрийн ашиглалтын худгуудын харагдах байдал	23
Зураг 16. Цэвэршүүлэх байгууламжаас гарч буй илүүдэл усыг усалгаанд ашигласан зарцуулалт	23
Зураг 17. Шугам сүлжээний засвар, угсралтын ажил гүйцэтгэж байгаа нь	24

Зураг 18. Хур тунадасны ус зайлуулж ногоон байгууламжинд ашиглах	24
Зураг 19. Хаягдал усны зөвшөөрөл, дүгнэлт	24
Зураг 20. “Хаанзаа” ХХК зөвлөх үйлчилгээ үзүүлж буй нь.....	25
Зураг 21. ШТС	25
Зураг 22. Түлшний машин болон ашигласан тос цуглуулах хэсэг.....	25
Зураг 23. Асгаралтын хариу арга хэмжээ үйлчилгээний талбайг цэвэрлүүлсэн байдал.....	26
Зураг 24. Асгаралтын иж бүрдэл байрлуулсан байдал	26
Зураг 25. Поошиг хадгалах талбайг бетон суурьтай болгосон байдал	26
Зураг 26. Хог ангилан ялгах түр цэгийн газар хөндөх зөвшөөрөл.....	27
Зураг 27. Цэвэр усны шугамын транс	27
Зураг 28. Хатуу хучилттай зам тавьсан байдал	28
Зураг 29. Раменскийн тор ашиглан ургамлын бүлгэмдэл тодорхойлж буй байдал.....	28
Зураг 30. Ургамлын зүйлийн бүрдэл тодорхойлсон байдал	29
Зураг 31. Шувуу суух үүр болон шувуу үргээгч суурилуулав	29
Зураг 32. Ногоон байгууламжийн арчилгаа.....	31
Зураг 33. Хаврын тарилт хийж буй байдал.....	31
Зураг 34. Ногоон байгууламжийн ажлын явц.....	33
Зураг 35. Төслийн 2025 онд хийгдэх ажлуудаас	34
Зураг 36. Төслийн талбайд үйл ажиллагаатай танилцаж хамтарч оролцсон байдал.....	35
Зураг 37. 2025 оны сургалтын дүн.....	37
Зураг 38. Нийт ажилтаны сургалт.....	37
Зураг 39. Ажилтнуудад сургалт явуулж буй байдал.....	37
Зураг 40. Ногоон оффисын сургалт	37
Зураг 41. 7 хоногийн цаг агаарын мэдээ	38
Зураг 42. Химийн бодисын агуулахад.....	38
Зураг 43. Аюулыг илрүүлэх, мэдээллэх хуудас.....	39
Зураг 44. Гал түймэрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах сургалт зохион байгуулж буй байдал.....	39
Зураг 45. Галын сараануудыг шинэчилсэн байдал	40
Зураг 46. Галын гидрантуудын ажиллагааг шалгаж бүрэн бүтэн байдлыг хангасан	40
Зураг 47. Хуванцар хаягдал цуглуулж буй байдал	42
Зураг 48. Хуруун зай цуглуулах.....	42
Зураг 49. Лабораторийн сав суулга болон принтер, хуруун зай бусад хаягдал.....	42
Зураг 50. Түмэн эгшиг ХХК-нд нийлүүлсэн аюултай хог хаягдлын акт, устгасан баримт	43
Зураг 51.Түр хогийн цэгийг сайжруулсан байдал.....	43
Зураг 52. Шинэ түр хогийн цэгийн барилгын ажлын явц	44
Зураг 53. Хогийн цэгт ариутгал хийлгэж байгаа нь.....	45
Зураг 54. Сар бүрийн цэвэрлэгээг зохион байгуулах зарлал	45
Зураг 55. Хог хаягдлын талаар постер хүргэж буй байдал	45
Зураг 56. Цэвэрлэгээ хийсэн ажлын тайлан хэсэг бүрээр	46
Зураг 57. ААХ болон ШҮХ-ийн гадна хуванцар ялгах торон сав байршуулсан.....	47
Зураг 58.110-р пост хогийн сав мөн оффис дотор.....	47
Зураг 59. Ангилан ялгах хогийн сав	47
Зураг 60. Аюултай хог хаягдал хүлээлгэн өгч буй байдал.....	48
Зураг 61. Хаягдал тос масло хүлээлгэн өгч буй байдал.....	48
Зураг 62. Хаягдал тос маслыг тусгай зориулалтын талбайд цуглуулан, хуримтлуулан түр хадгалж буй байдал	48
Зураг 63. Үйлдвэрийн хяналтын цооногийн усны түвшин харьцуулсан дүн, 2021-2025	50
Зураг 64. Хяналтын цооногуудын байршлын зураг.....	51
Зураг 65. Үйлдвэрийн хяналтын цооногуудад хэмжилт хийж буй байдал.....	51

Зураг 66. Хаанзаа ХХК зөвлөх үйлчилгээ үзүүлж буй байдал	52
Зураг 67. Бохир усны шинжилгээ авч буй байдал.....	52
Зураг 68. Хөрсний дээж авч буй байдал.....	55
Зураг 69. Үйлдвэрийн талбайн агаар, тоосны хэмжилт.....	56
Зураг 70. Үйлдвэр орчмын нийт тоосны концентрацийн хэмжилтийн үр дүн (мг/м3).....	56
Зураг 71. Дуу шуугианы хэмжилтийн үр дүн.....	57
Зураг 72. Дуу шуугианы хэмжилт хийж буй байдал.....	57
Зураг 73. Дуу шуугианы хэмжилтийн үр дүн.....	57
Зураг 74. Дуу шуугианы хэмжилт хийж буй байдал.....	58
Зураг 75. Үйлдвэр орчмын ургамлын судалгаа хийж буй байдал	59
Зураг 76. Үйлдвэр, уурхайн бүртгэлийг харьцуулсан байдал.....	60
Зураг 77. Амьтны үзэгдлийн график	60
Зураг 78. Нөлөөллийн бүсийн малчдаар явсан ажлын тайлан.....	62
Зураг 79. Нөлөөллийн бүсийн иргэдтэй хэмжилт хийж буй байдал	63
Зураг 80. Нөлөөллийн бүсийн айлуудын худгийн усны түвшин хэмжилт.....	63
Зураг 81. Ажилчдад сургалт орж буй байдал	63
Зураг 82. Нөлөөллийн бүсийн малчин өрхүүдэд өвс тэжээл тараасан бүртгэл	64
Зураг 83. Малчин өрхүүдэд өвс тарааж буй байдал.....	65
Зураг 84. Эссэ бичгийн уралдааны шагнал гардуулж, усны тухай сургалт оров.....	65
Зураг 85. Цомог багийн хуралд тайлан танилцуулж буй байдал.....	66

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Түүхий эд.....	8
Хүснэгт 2. Цемент үйлдвэрлэл, борлуулалт, 2025.01-09 сар	12
Хүснэгт 3. Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын хэрэгжилт.....	15
Хүснэгт 4. Үйлдвэрийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	16
Хүснэгт 5. Арга хэмжээний төлөвлөгөө.....	29
Хүснэгт 6. Усны хяналт шинжилгээ	49
Хүснэгт 7. Усны микробиологийн шинжилгээ	49
Хүснэгт 8. Үйлдвэрийн хяналтын цооногийн усны түвшиний харьцуулсан дүн, 2020-2023	50
Хүснэгт 9. Хөрсний шинжилгээ.....	53
Хүснэгт 10. Хөрсний агрохимийн шинжилгээний дүн.....	53
Хүснэгт 11. Хөрсний механик бүрэлдэхүүний шинжилгээний дүн.....	54
Хүснэгт 12. Хөрсний хүнд металлын шинжилгээ	54
Хүснэгт 13. Микробиологи	55
Хүснэгт 14. Агаарын шинжилгээний үйл явц	55
Хүснэгт 15. Үйлдвэр орчмын агаар, тоосны хэмжилтийн дүн	56
Хүснэгт 16. Урагмлын мониторинг	58
Хүснэгт 17. Ургамлын зүйлийн бүрдэл.....	59
Хүснэгт 18. Удирдлага зохион байгуулалтын биелэлт.....	60


ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“МАК Цемент” ХХК нь Дорноговь аймгийн Даланжаргалан суманд байрлах Хөх Цавын шохойн чулуун ордыг түшиглэн баригдсан хуурай аргын цементийн үйлдвэр юм. Тус үйлдвэр нь 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн олон улсын евро стандартын цементийг үйлдвэрлэх, зорилтот зах зээлд хүргэхэд томоохон алхам болсон. “МАК Цемент” ХХК нь өндөр хөгжилтэй орнуудад мөрддөг олон улсын стандартыг эх орондоо нэвтрүүлж, бодит ажил хэрэг болгон хариуцлагатай үйлдвэр, уул уурхайн жишиг тогтоохыг зорьж, Монгол Улсад өрнөж буй барилгын бүхий л салбар, чиглэлд дотоодын нөөц бололцоогоор хангах боломжийг олгон хувь нэмрээ оруулан ажиллаж байна. Тус компани нь төслийн хүрээнд явагдаж байгаа бүхий л үйл ажиллагааны явцад байгаль орчыг хамгаалах багц хууль, стандартуудыг даган мөрдөж, төслийн үйл ажиллагааны явцад гарч байгаа сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, байгаль орчныг хамгаалах зорилготойгоор ажилладаг.


“МАК Цемент” ХХК нь дараах зорилтыг дэвшүүлэн ажилладаг. Үүнд:

- Байгалийн нөөц баялагийг урт удаан хугацаанд тогтвортой, үр ашигтай зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар баримталж ирсэн төрийн бодлогыг хэрэгжүүлж, эрх бүхий байгууллагаас баталсан байгаль орчны стандарт, хэм хэмжээ, дүрэм журмыг чанд сахин биелүүлж, дотоодын болон хөндлөнгийн байгаль орчны хяналтыг тогтмол гүйцэтгэх;
- Улсын болон орон нутгийн хэмжээнд тогтвортой үйл ажиллагаа явуулдаг байгаль орчныг хамгаалах чиглэлийн төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах;
- Олон улсын байгаль орчны байгууллагууд болон байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи бүхий туршлагатай компаниудтай хамтран ажиллаж, улмаар олон улсын байгаль орчны стандартуудыг өөрийн үйлдвэрлэл, үйл ажиллагаанд нэвтрүүлэх;
- Нөхөн сэргээгдэхгүй байгалийн нөөц баялгийг ариг гамтай, хаягдалгүй технологи болон дахин боловсруулах аргаар ашиглах;
- Байгалийн нөөцийн ашиглалтын үр ашгийг өндөр түвшинд байлгах зорилгоор тогтмол судалгаа шинжилгээг явуулж орчин үеийн үр ашигтай техник, технологийг үйлдвэрлэлдээ тууштай нэвтрүүлэх;
- Үйлдвэрлэл, уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн иргэдийн соёл, өв уламжлалыг хүндэтгэн хамгаалах, тэдний биет өв, ёс заншлын талаархи мэдээлэл, тэдгээрийн ач холбогдлыг компанийн ажилчдад тогтмол таниулах;
- Өөрийн компанийн байгаль орчны талаар баримтлах бодлого зарчмыг хамтран ажиллаж буй түнш, гэрээт гүйцэтгэгч нарт зааж таниулах, тавих шаардлагыг өндөржүүлэх замаар байгаль орчны чиглэлээр тэдний хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэх;

Хөх цавын цемент шохойн үйлдвэр нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших бөгөөд МАК Цемент ХХК нь 152.4 га талбайг 60 жилийн хугацаатайгаар эзэмшдэг. Жилд 900'000.00 тн/жил чулуунцар буюу 1'000'000.00 тн цемент үйлдвэрлэх төслийн хүчин чадалтай хуурай аргын цементийн үйлдвэр юм.



Зураг 1. Үйлдвэрийн байршил



Зураг 2. Ерөнхий төлөвлөлтийн зураг

Түүхий эд

Цементийн үйлдвэрлэлд шаардлагатай үндсэн түүхий эд материалын орд газрын лицензийг МАК Цемент ХХК нь компани эзэмшдэг тул үйлдвэрийг хямд өртөгтэй түүхий эдээр хангаж, үйлдвэрлэлийн зардлыг бууруулах, улмаар зах зээлд хямд өртөгтэй цемент нийлүүлэх боломжтой.

Хүснэгт 1. Түүхий эд

Түүхий эдүүд	Түүхий эдүүдийн байршил	Жилийн хэрэглээ, тн	Тээвэрлэх зай
Шохойн чулуу	Дорноговь аймаг, Даланжаргалан сум, Хөх цавын орд	1,338,756.6	Шинээр сайжруулсан шороон зам зассан 10,5 км
Гөлтгөнө	Дундговь аймаг, Дэлгэрхангай сум, Ширээгийн хөндий гөлтгөнийн орд	118,212.0	408 км
Шавар	Дорноговь аймаг, Даланжаргалан сум, Шар хоолойн шавар-элсний орд	328,310.1	12,1 км
Элс	Дорноговь аймаг, Даланжаргалан сум, Шар хоолойн шавар-элсний орд	45,918.2	12,1 км
Нүүрс	Дундговь аймаг, Баянжаргалан сум, Хөөтийн нүүрсний орд	165,194	115 км
Нүүрс	Өмнөговь аймаг, Цогтцэций сум, Тавантолгойн нүүрсний орд		Төмөр замаар
Үнс	Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, IV-р цахилгаан станц	5,000	Төв замаар 330 км
Төмрийн хүдэр	Баргилтын орд	22,067	53 км

Үйлдвэрийн хүчин чадал

Цементийн үйлдвэр нь жилд 900,000 тн/жил чулуунцар буюу 1,051,200 тн цемент үйлдвэрлэх хүчин чадалтай.

Үндсэн тоног төхөөрөмжүүд

Цементийн үйлдвэрийн тоног төхөөрөмжүүдийг Дани улсын FLSmith компанийн тоног төхөөрөмжүүдээр угсарсан ба байгальд ээлтэй, хаягдалгүй, хуурай аргын хамгийн сүүлийн үеийн дэвшилтэд технологитой 100% автомат ажиллагаатай үйлдвэр юм. Түүхий эдийн бутлуур, силосууд, шатаах зуух, туузан дамжлагуудаас гарах тоосыг уутат филтер, цахилгаан филтерээр тоосыг шүүн агаарыг цэвэршүүлнэ. Бутлууруудын амсар дээр мөн бороожуулах систем суурилуулсан байна. Энэ нь мөн нойтон аргаар агаарыг цэвэршүүлэх юм. Зуухны яндан дээр хий хянагч мониторингийн системтэй. Шатаах зуухнаас гарах хаягдал үнсийг цементийн чанар сайжруулах нэмэлт түүхий эд болгон ашиглана. Цемент үйлдвэрлэхэд ус ашиглахгүй. Харин технологит хөргүүрийн зориулалтаар усыг ашиглах бөгөөд уг усаа цикл маягаар дахин ашиглана.

- 450 тонн/цагийн хүчин чадалтай шохойн чулууны бутлуур
- 100 тонн/цагийн хүчин чадалтай шавар болон нэмэлт түүхий эдийн бутлуур
- 35 тонн/цагийн хүчин чадалтай гөлтгөнийн бутлуур
- 100 тонн/цагийн хүчин чадалтай нүүрсний бутлуур
- Хоногт 3000тн чулуунцар үйлдвэрлэх хүчин чадалтай эргэх зуух

- 2 x 10000 тонны шохойн чулуу гөлтгөний агуулах

Цементийн үйлдвэрийн цементийн марк:

- PC 42.5: 648,000 тн/жил
- PC 52.5: 207,000 тн/жил
- PC 62.5: 196,200 тн/жил

Цементийн савалгаа:

- Савласан (60%): 735,000 т/жил
- Савлаагүй (40%): 316,200 т/жил

Үйлдвэрлэлийн өдөр тутмын үйл ажиллагаа, технологийн дараалал:


Үндсэн түүхий эдийг өөрийн орд болох Хөх цавын шохойн чулууны уурхайгаастээвэрлэн үйлдвэрийн анхан шатны боловсруулалт болох анхан шатны бутлуурт хүлээнэвнэ. Үүний дараа бутлуураас урьдчилан жигдрүүлэгч агуулахадшохойн чулууны титрээс хамааруулан ялгаж овоолго үүсгэнэ. Технологичийн зааврааршохойн чулууг титрээс нь хамааруулан түүхий эдийн тээрэмд ачаалан тодорхой хэмжээнийхувийн гадаргуутай болтол нь нунтаглана. Шохойн чулуутай хамт төмрийн хүдэр, Гөлтгөнө, Шавар, элс зэрэг түүхий эд материалыг технологичийн заавраар нэмж хамтад нь тээрэмдэнэ.


Тээрмээс гарсан нунтаг түүхий эд материалыг зориулалтын битүү силос агуулахадхадгална. Үүний дараа дунд шатны боловсруулалт болох клинкер (чулуунцар) үйлдвэрлэхажиллагаа эхэлнэ. Үйлдвэрлэл эхлэхэд өөрийн орд болох Элдэв, Хөөтийн нүүрсний уурхайнуудааснүүрсийг тээвэрлэн буталж, агуулахадхадгална. Түүхий эдийн битүүагуулахаас тодорхой хэмжээгээр тугнаж, урьдчилан халаах цамхагт ачаална. Урьдчилан халаах цамхагийн дээд температур 1000°C хүртэл боловсруулалт хийгдэнэ. Энэ үед шохойнчулуу задарч клинкерийн эхний үе шат эхэлнэ.

Клинкер нь 1350-1450°C-д бий болно. Энэ нь үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмж болох 4.35м*51м-тэй эргэх зуухандболовсруулагдана. Клинкер нь зуухнаас 300-6000°C-ийн температуртай гаран хөргүүрээрдамжина. Хөргүүрээс 50-1000°C-тай клинкерийн агуулахад битүү болон задгайгаар хадгалагдана. Үүний дараа эцсийн шатны боловсруулалтын ажил эхэлнэ.

Клинкерийг туузан дамжуургаар агуулахаас цементийн тээрэмд ачаална. Мөн Гөлтгөнө, Шохойн чулуу, үнсийг технологичийн заавраар тодорхой хэмжээнд нэмж өгнө. Цемент нь100-1100°C хүртэлх температурт нунтаглагдана. Хувийн гадаргуу нь 3500-3800см²/гр хүртэлхэмжээнд нунтаглагдана. Гөлтгөнө нь 100-1100°C-д боловсруулагддаг. Тээрмээс гарч буйнунтаг цементийг хийн дамжуурга буюу аэрожелоб дамжуургаар нэг бүр нь 10000тн-ын 4шсилост хадгална. Хадгалагдсан цементийг бүрэн автоматчилсан савлах, түгээх цехэд дамжуулан зах зээлд гаргана.

Технологийн схем






Зураг 3. Технологийн схем

2025 ОНЫ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


2025 оны 1-9 сард олон улсын стандарт, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг хангасан ОРС-42.5 портланд цемент **699.9** мянган тонныг үйлдвэрлэж (төлөвлөгөөний биелэлт 94%), **764.6** мянган тонныг (төлөвлөгөөний биелэлт 100%) борлуулсан.

Хүснэгт 2. Цемент үйлдвэрлэл, борлуулалт, 2025.01-09 сар

Сар	Үйлдвэрлэл			Борлуулалт		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт %	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт %
1 сар	-	8,047		14,406	15,476	
2 сар	44,750	29,510	66%	20,883	16,332	71%
3 сар	45,788	17,679	39%	41,930	37,628	84%
4 сар	71,043	88,560	125%	79,969	89,695	108%
5 сар	102,765	114,516	111%	106,047	118,805	110%
6 сар	132,000	101,334	77%	128,935	120,067	92%
7 сар	110,000	121,911	111%	104,464	104,927	99%
8 сар	123,200	122,927	100%	134,064	148,937	110%
9 сар	114,400	94,365	82%	130,130	112,687	86%
Нийт	743,945	698,849	94%	760,830	764,553	100%



Зураг 4. Цемент үйлдвэрлэл, 2025.01-09 сар



Зураг 5. Цемент борлуулалт


ҮЙЛДВЭРИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Цемент шохой үйлдвэрлэх төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг 2022 онд боловсруулсан төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тодорхойлсон байдаг. Төсөл хэрэгжиж байгаа бүс нутагт Мак Цемент ХХК-аас гадна Эко Хэлхээ ХХК-ны жонш баяжуулах үйлдвэр, нүүрс олборлож буй Чингэсийн хар алт, Штайнколе, Пауэрленд ХХК-ууд, төмрийн хүдэр олборлох МГМК ХХК зэрэг аж ахуйн нэгжүүд төсөл хэрэгжүүлдэг учраас тухайн газрын хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөлөл нь хам шинж чанартай юм.

Цемент шохой үйлдвэрлэх төслийн үйл ажиллагаанаас үүсэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг түүнд өртөх орчноор нь буюу агаар, гадаргын болон газар доорх ус, хөрс, амьтан ургамлын аймгийг хамруулан дараах байдлаар тодорхойлсон.



Зураг 6. Агаарын чанарт үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд



Зураг 7. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд



Зураг 8. Усны чанарт үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд



Зураг 9. Ургамлан нөмрөг, амьтны аймагт үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд

Тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх нөлөөлөл

Цемент шохойн үйлдвэрийн талбайд хамгийн ойр орших улсын тусгай хамгаалалттай газар бол Их нартын байгалийн нөөц газар 24 км, орон нутгийн хамгаалалттай газар Хөшөөгийн энгэр 11 км-т оршдог байна. Тиймээс үйлдвэрлэлийн явцад тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх нөлөөлөл байхгүй.

ЦЕМЕНТ ШОХОЙН ҮЙЛДВЭРИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ, ҮНДСЭН ҮР ДҮН

Дорноговь аймгийн Даланжаргалан суманд орших Цемент шохойн үйлдвэрийн Байгаль орчны менежмент төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг боловсруулахдаа БОАЖЯ-ны сайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А-618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежмент төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримталсан бөгөөд тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын биелэлтийн байдлыг нэг бүрчлэн тодорхойлж, шаардагдсан хөрөнгө зардлыг тооцсон бөгөөд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлтийн хэсэгт хяналт шинжилгээний ажлын үр дүнг дэлгэрэнгүй хэлбэрээр тусгасан болно.

Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд түүний биелэлтийн тоон үзүүлэлтийг дараах хүснэгтэнд нэгтгэн илэрхийлэв.

Хүснэгт 3. Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын хэрэгжилт

д/д	Байгаль орчны хамгаалах арга хэмжээний төрөл	Төлөвлөсөн ажлын тоо	Гүйцэтгэсэн ажлын тоо	Хийгдэж буй болон хойшлогдсон ажлын тоо
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	15	15	-
2	Орчны тохижилт цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	3	3	-
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	1	1	-
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох	-	-	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-	-	-
6	Осол, эрсдэлийн менежментийн	6	6	-
7	Хог хаягдлын менежмент	9	9	-
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	13	13	-
9	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	8	8	-
10	Олон нийтэд тайлагнах үйл ажиллагаа	1	1	-
	Нийт	56	56	-

2025 онд Цемент шохойн үйлдвэр нь Байгаль орчны менежмент төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлсэн гол үйл ажиллагаанууд, түүний үр дүнг дурдвал.

- Үйлдвэрийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын хүрээнд хавар, намрын тарилтаар нийт 8525 мод сөөг тарьж усалгаа, арчилгааг хийж гүйцэтгэсэн.
- Мод үржүүлгийн талбайн хүлэмжэнд шар хуайс, алтан харгана, буйлс, жигд, зэрэг модны үрийг тарьж 85 хувийн ургалттай ургуулав.
- Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд Их нартын БНГ-тай хамтран хар сүүлт зээрийн судалгаа, хамгаалал төсөлд хамтран ажиллаж байна.
- Цемент шохойн үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй гол сөрөг нөлөөллийг хянах зорилгоор агаар тоос, ус, хөрс, амьтан, ургамлын хэмжилт, орчны хяналт шинжилгээний ажлыг тогтмол хийж гүйцэтгэсэн.

1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 4. Үйлдвэрийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр					
1	Орчны тоосжилтыг дарах зорилгоор усалгааг тогтмол хийж байх	Үйлдвэрийн хэмжээнд	Үйлдвэрийн зам талбайн усалгааг хуваарийн дагуу тогтмол усны белазаар усалгаа хийж байна.	100,000	Тухай бүрт
2	Тээврийн хэрэгслүүдэд хурдны хязгаар тогтоох, тэдгээрт хяналт тавих зорилгоор машины GPS суурилуулах	Үйлдвэрийн хэмжээнд	Үйлдвэрийн талбайд машин механизмуудын хурдыг хязгаарлах, тоосжилт үүсгэхээс урьдчилан сэргийлэх зорилготойгоор Гайхам GPS суурилуулан өдөр бүр хурдны хязгаарыг хянаж байна.	420,000	Жилийн турш
33	Уутан шүүлтүүрийг гэмтэж муудсан үед цаг алдалгүй солих, битүүмжлэлд хяналт тавьж засвар үйлчилгээг тогтмол хийх	Үйлдвэрийн хэмжээнд	Үйлдвэрийн шат дамжлагуудаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор ханцуйт болон уутан шүүлтүүрийг тухай бүрт солиж байршуулдаг.	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүрт
4	Төслийн үйл ажиллагаанд ашиглах тээврийн хэрэгслүүдийг тогтмол үзлэг оношилгоонд оруулах	Үйлдвэрийн хэмжээнд	4 сард Дорноговь аймгийн автотээврийн газрын үзлэгт тээврийн хэрэгслүүд бүрэн хамрагдсан	Үйл ажиллагааны зардлаас	Жилдээ
5	Үйлдвэрийн бүсэд агаарын чанарын хэмжилт хийх	Үйлдвэрийн хэмжээнд	Агаар тоосны хэмжилтыг Дорноговь аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний газраар жилд 2 удаа хийлгэдэг мөн дотооддоо сар бүр хэмжилт хийж байна.	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүрт
Усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр					
6	Технологийн зориулалтаар ашиглаж буй өөрийн худгуудын тоолууранд хяналт тавьж, сумын байгаль орчны мэргэжилтэнтэй	Гүний худаг	Үйлдвэрийн ашиглалтын худгуудын тоолуурын заалтыг сар бүрийн 30-нд Даланжаргалан сумын БОМэргэжилтэнээр хянуулан	Үйл ажиллагааны зардлаас	Жилдээ Тухай бүр

	хамтран усны хэрэглээг хянан бүртгэл хөтлөх ажлыг зохион байгуулах		баталгаажуулж, усны төлбөрийг төлж байна.		
7	Үйлдвэрийн хаягдал усыг ногоон байгууламж ба зам талбайн усалгаанд дахин ашиглах	Үйлдвэр	Үйлдвэрийн технологиос гарсан хаягдал усыг ногоон байгууламж болон зам талбайн усалгаанд дахин ашиглахаар ЦБ-г засаж сайжруулж байна	Үйл ажиллагааны зардлаас	Жилдээ Тухай бүр
	Газрын доорх усны хяналтын цооногийг автоматжуулах Үйлдвэрийн бүсэд байгаа ногоон байгууламжийн усалгаа арчилгааны явцад хөрсний чийг хэмжигч багаж ашиглан усалгааг хийх	Үйлдвэр	Үйлдвэрийн худгуудын хяналтын цооногийн хэмжилтийг хийж газар доорх усны түвшинг хянаж байна	1,000,000	Жилдээ Тухай бүр
8	Хаягдал усыг цэвэрлэх байгууламжийг сайжруулах	Үйлдвэр	Хаанзаа ХХК-тай хамтарч ЦБ-г сайжруулах зөвлөх үйлчилгээ авч зөвлөмжийн дагуу сайжруулах худалдан авалтыг зохион байгууж байна	Үйл ажиллагааны зардлаас	Жилдээ Тухай бүр
9	Хаягдал усны дүгнэлт гаргуулах, зөвшөөрөл болон гэрээ байгуулах	Үйлдвэр	“Ус бохирдуулсны төлбөрийн тухай” хуулийн дагуу Усны газраар хаягдал усны дүгнэлтийг гаргуулж, УГТХДТалын сав газрын захиргаатай гэрээ байгуулсан. Төлбөрийг төлсөн	Үйл ажиллагааны зардлаас	Гэрээг байгуулж төлбөрийг цаг тухайд төлж барагдуулсан байх
10	Ахуйн бохир ус, хатуу хаягдлаас урсац хөрсөнд алдагдахаас сэргийлэх, асгарсан тохиолдолд бохирдсон байдлаас шалтгаалан саармагжуулах, цэвэрлэх арга хэмжээ	Үйлдвэр	Тайлант онд үйлдвэрийн бохир ус цэвэрлэх байгууламжинд тогтмол үзлэг шалгалт хийж ажилласан мөн Хаанзаа ХХК гэрээ байгуулж зөвлөх үйлчилгээ авч ажиллаж байна.	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүр

Хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр					
11	Шатах тослох материалыг битүүмжлэлтэй саванд хадгалах		Үйлдвэрийн засвар үйлчилгээний төвөөс гарах шатах тослох материалыг 5 тн, 10 тн-ын ёмкост түр хадгалж аюултай хог устгалын “Мон пити ойл” ХХК гэрээт компанид тайлант онд 10 тонн хаягдал тос нийлүүлсэн. Мөн засгийн газрын шийдвэртэй хөндлөн тэнхлэгийн зам ангийн Хүслэнт бүтээмж ХХК-нд 5 тн тос нийлүүлсэн.	Үйл ажиллагааны зардлаас	Жилдээ
12	Тосны асгаралтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах	Үйлдвэрийн хэмжээнд	Тосны асгаралтаас урьдчилан сэргийлэх асгаралтын сургалт зааварчилгааг шинэ ажилтан болон бүх ажилчдад орсон. Асгаралт үүсэж болзошгүй цэгүүдэд асгаралтын иж бүрдэл байршуулсан. Мөн тостой поошиг байрлуулах талбайг бүтэн бетон цутгаж хөрсөнд асгарахаас хамгаалсан, хаягжуулсан	1,000,000	Жилдээ
13	Газар хөндөх зөвшөөрөл авах, олгох тохиолдолд бүртгэл хөтлөх		Үйлдвэрийн бүс дотор нийт 1 удаа газар хөндөх зөвшөөрөл олгосон.	Үйл ажиллагааны зардлаас	Жилдээ
Ургамал, амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр					
14	Үйлдвэр орчмын бэлчээрийн талбай хорогдох	Үйлдвэр	Ургамалжилтын судалгааг 7,9 саруудад хийсэн	400,000	2 удаа
15	Зэрлэг ан амьтан хамгаалах	Үйлдвэр орчмын бүс	Шинээр татсан цахилгааны шугамууд дээр шувуу суух үүр болон шувуу үргээгч суурилуулсан.	1,000,000	9 сард
Нийт зардал				3,920,000	

* Үйл ажиллагааны зардлаар хийгдсэн ажлын өртөг багтаагүй дүн

Орчны тоосжилтыг дарах зорилгоор усалгааг тогтмол хийж байх


Үйлдвэрийн бүсэд зам талбайн тоосжилтыг бууруулах зорилгоор үйлдвэрийн дотор талбайд усалгааг тогтмол хийж байна.



Зураг 10. Зам талбайн усалгаа хийж буй байдал

Тээврийн хэрэгслүүдэд хурдны хязгаар тогтоох, тэдгээрт хяналт тавих зорилгоор машины GPS суурилуулах

Үйлдвэрийн бүсэд олон салаа зам гаргахгүй, батлагдсан маршрутаар зөвшөөрөгдсөн зассан замаар зорчиж, хөдөлгөөнд оролцож байна. Машин механизмуудын хурдыг хязгаарлах зорилгоор дотоод журмын дагуу “Гайхам” GPS хяналтын программ ашиглан тээврийн хэрэгслүүдэд байнгын хяналт тавин ажиллаж байна. Хяналтаар 71 орчим тохиолдол илэрсэн нь 3-10 км/цаг хурд хэтрүүлсэн байсан ба ихэнх нь гүйцэж түрүүлэх, шинэ жолооч зэрэг байсан. Хэтрүүлсэн хурд нь аюул учруулах эрсдэл бага хөдөлгөөн сийрэг газруудад тохиолдсон байна. Хурд хэтрүүлсэн жолооч нарт анхааруулга өгөх, сургалт явуулах, сахилгын шийтгэл өгч ажилладаг.



Хурд хэтрүүлэлтийн тайлан


Хамрах хугацаа: 2025 оны 10-р сарын 11 07:00 - 2025 оны 10-р сарын 12 07:00
(өдөр бүр 00:00 - с 23:59 хүртэл)

Бэлтгэсэн: 2025 оны 10-р сарын 12 07:33
Цагийн бүс: Улаанбаатар

Агуулга	
Хово #04 / 77-99 ТТА /	3
Хово #09 / 77-44 ТТА /	5
Хово #06 / 66-22 ТТА /	6
Хово #08 / 66-44 ТТА /	8
Хово #16 / 98-51 УАН /	10
38-14 УАС / Land-78 /	11
25-37 УАС / Land-78 /	13
#01 57-15 УКМ / Автобус /	15
29-41 УАС / Land-79 /	17

Хово #04 / 77-99 ТТА / , 2025 оны 10-р сарын 11 07:00 - 2025 оны 10-р сарын 12 07:00

Хурд




Хурд хэтрүүлэлт (их 40 км/ц дээш хугацаанд 1 мин.)

Эхлэх хугацаа	Урсгалын хугацаа	Дундаж хурд, км/ц	Дээд хурд, км/ц	Хаяг
2025 оны 10-р сарын 11 (Бя) : 29				
07:40	00:09	40	50	Төх шавын зам/ Даланжиргалан сум, Дорноговь
08:50	00:01	42	42	Төх шавын зам/ Даланжиргалан сум, Дорноговь
08:52	00:01	43	44	Төх шавын зам/ Даланжиргалан сум, Дорноговь
08:54	00:01	43	46	Төх шавын зам/ Даланжиргалан сум, Дорноговь
09:51	00:02	42	42	Төх шавын зам/ Даланжиргалан сум, Дорноговь
10:00	00:09	43	45	Төх шавын зам/ Даланжиргалан сум, Дорноговь
10:09	00:01	42	44	Төх шавын зам/ Даланжиргалан сум, Дорноговь
10:46	00:01	42	44	Төх шавын зам/ Даланжиргалан сум, Дорноговь
11:17	00:01	42	44	Төх шавын зам/ Даланжиргалан сум, Дорноговь
11:22	00:01	41	42	Төх шавын зам/ Даланжиргалан сум, Дорноговь
11:27	00:09	43	45	Төх шавын зам/ Даланжиргалан сум, Дорноговь
11:57	00:02	42	45	Төх шавын зам/ Даланжиргалан сум, Дорноговь
12:22	00:01	42	43	Төх шавын зам/ Даланжиргалан сум, Дорноговь
12:27	00:01	42	42	Төх шавын зам/ Даланжиргалан сум, Дорноговь
12:28	00:01	42	44	Төх шавын зам/ Даланжиргалан сум, Дорноговь
12:59	00:01	42	44	Төх шавын зам/ Даланжиргалан сум, Дорноговь
13:26	00:09	44	46	Төх шавын зам/ Даланжиргалан сум, Дорноговь
15:19	00:05	43	46	Төх шавын зам/ Даланжиргалан сум, Дорноговь
15:26	00:01	43	46	Төх шавын зам/ Даланжиргалан сум, Дорноговь
16:07	00:01	42	44	Төх шавын зам/ Даланжиргалан сум, Дорноговь
16:29	00:01	42	42	Төх шавын зам/ Даланжиргалан сум, Дорноговь

Хурд хэтрүүлэлтийн тайлан: Хово #04 / 77-99 ТТА / , Хуудас 3

Хово #06 / 66-22 ТТА / , 2025 оны 10-р сарын 11 07:00 - 2025 оны 10-р сарын 12 07:00

Хурд




Хурд хэтрүүлэлт (их 40 км/ц дээш хугацаанд 1 мин.)

Эхлэх хугацаа	Урсгалын хугацаа	Дундаж хурд, км/ц	Дээд хурд, км/ц	Хаяг
2025 оны 10-р сарын 11 (Бя) : 00				
07:00	00:01	42	44	Төх шавын зам/ Даланжиргалан сум, Дорноговь
07:01	00:01	44	47	Төх шавын зам/ Даланжиргалан сум, Дорноговь
07:04	00:02	45	48	Төх шавын зам/ Төх шавын цураай/ Даланжиргалан сум, Дорноговь
07:41	00:01	44	47	Төх шавын зам/ Даланжиргалан сум, Дорноговь
07:47	00:02	45	48	Төх шавын зам/ Даланжиргалан сум, Дорноговь
08:30	00:04	44	45	Төх шавын зам/ Даланжиргалан сум, Дорноговь
08:35	00:01	44	42	Төх шавын зам/ Даланжиргалан сум, Дорноговь
08:36	00:04	45	53	Төх шавын зам/ Даланжиргалан сум, Дорноговь
08:59	00:01	44	45	Төх шавын зам/ Даланжиргалан сум, Дорноговь
09:06	00:01	44	47	Төх шавын зам/ Даланжиргалан сум, Дорноговь
09:40	00:06	47	53	Төх шавын зам/ Даланжиргалан сум, Дорноговь
09:47	00:01	43	47	Төх шавын зам/ Даланжиргалан сум, Дорноговь
09:49	00:03	43	46	Төх шавын зам/ Даланжиргалан сум, Дорноговь
10:12	00:01	46	48	Төх шавын зам/ Даланжиргалан сум, Дорноговь
10:30	00:05	43	46	Төх шавын зам/ Даланжиргалан сум, Дорноговь
10:43	00:06	46	54	Төх шавын зам/ Даланжиргалан сум, Дорноговь
11:10	00:02	45	48	Төх шавын зам/ Төх шавын цураай/ Даланжиргалан сум, Дорноговь
11:19	00:02	43	45	Төх шавын зам/ Даланжиргалан сум, Дорноговь
11:36	00:06	45	48	Төх шавын зам/ Даланжиргалан сум, Дорноговь

Зураг 11. Хурд хэтрүүлэлтийн тайлан мэдээ

Утан шүүлтүүрийг гэмтэж муудсан үед цаг алдалгүй солих, битүүмжлэлд хяналт тавьж засвар үйлчилгээг тогтмол хийх

Цемент шохойн үйлдвэрийн бүх дамжлага тоос шүүх хэсгүүдэд Bag filter буюу ханцуйт фильтр суурилагдсан байдаг бөгөөд 4 төрлийн ханцуйт шүүлтүүрийн уутыг ашиглаж байна. 50 ширхэг ханцуйт шүүлтүүр Мөн Electrostatic precipitator буюу цахилгаан тоос шүүх байгууламж нь халуун материал сорох зориулалттай клинкер хөргүүрээс тоос сорох хэсэгт суурилагдсан байдаг.



Зураг 12. Ханцуйт шүүлтүүрийн байрлал

Үйлдвэрийн бүсэд агаар тоосны хэмжилт хийх


Үйлдвэрийн агаар, тоосны хэмжилтийг 6 байршилд 2025 оны 6,9-р саруудад Дорноговь аймгийн УЦУОШГ-аар хийж гүйцэтгүүлсэн. Мөн дотооддоо тоос болон агаарын чанарын хэмжилтийг сар бүр тогтмол хийж хариу арга хэмжээний тайлан авч байна.

Технологийн зориулалтаар ашиглаж буй худгуудын тоолууранд хяналт тавьж, сумын байгаль орчны мэргэжилтэнтэй хамтран усны хэрэглээг хянан бүртгэл хөтлөх

Технологийн зориулалтаар ашиглаж буй худгуудын тоолуурын бүрэн бүтэн байдалд тогтмол хяналт тавьж, Даланжаргалан сумын байгаль орчны мэргэжилтэнтэй хамтран сар бүрийн 30-нд тоолуурын заалтыг авч баталгаажуулдаг. Худгийн тоолууруудыг салгах, суурилуулах, лацдуулах ажлыг “Чандмань Илч” ХХК хамтран гүйцэтгэсэн.






Зураг 13. “Чандмань Илч”ХХК тоолуур суурилуулж буй байдал 2025.04 сар


БОТХХ




ХУДГИЙН ТООЛУУР САЛГАСАН АКТ

2025.10.09

Хөх цавын уурхай, ЗУТ, хагас кокс, амрах байрны арын нэгдсэн байгууламжийн худгийн тоолуур, угсруулт, салгалт, лацдуулах ажлыг экологийн мэргэжилтэн Б.Даваа, ус дулаан, хангамжийн менежер Б.Болорцэцэг, Даланжаргалан сумын “Чандмань илч” ХХК болон Даланжаргалан сумын байгаль орчны мэргэжилтэн С.Дандржаватар нарын бүрэлдэхүүнтэй хийж гүйцэтгэв.

Зураг 1. Тоолуур салгах үеийн үйл явц

Зураг 2. Тоолуурын салгах үеийн шалт

ЗУТ, АМРАХ БАЙРНЫ АР, ХӨХ ЦАВЫН УУРХАЙ, ХАГАС КОКСЫН ХУДГИЙН ТООЛУУРЫГ САЛГАЖ ЛАЦЫГ АВАВ. 2025.10.09

Зураг 14. Худгийн тоолуур салгасан акт 2025.10.09



Зураг 15. Үйлдвэрийн ашиглалтын худгуудын харагдах байдал

Үйлдвэрийн хаягдал усыг ногоон байгууламж ба зам талбайн усалгаанд дахин ашиглах

Ус цэвэршүүлэх байгууламжаас гарч буй илүүдэл усыг зам талбай, ногоон байгууламжийн усалгаанд ашигладаг ба усны хэрэглээг тоолуурын заалтаар хянан ажилладаг. Мөн 2017-2024 оны хооронд нийт ашигласан ус 81% тай байна.

2024 ОНЫ 1.000.000 ТОНН ЦЕМЕНТ ҮЙЛДВЭР.ТЭХ УСНЫ ЗАРЦУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ														
	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар	Нийт	
ТОНН ЦЕМЕНТ ҮЙЛДВЭР.ТЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ														
Цемент үйлдвэрлэл ОРС 42.5	100	-	52,640	44,400	71,273	111,833	122,850	94,185	139,035	134,550	127,650	62,900	38,685	1,000,000
Цементийн гэрээм ажиглалт хонго	0	17.5	16	21.5	31	30	21	31	30	30	20	17	12	260
Цементийн гэрээм ажиглалт цаг	0	16	15	17	18.5	21	23	23	23	23	17	17	17	17
Хонгог үйлдвэрлэх цемент	0	3,008	2,775	3,315	3,608	4,095	4,485	4,485	4,485	4,255	3,145	3,145	3,145	31,455
Цагийн дундаж зүчин чадал	-	188	185	195	195	195	195	195	195	195	185	185	185	185
Усны норм	-	0.024	0.024	0.024	0.024	0.024	0.024	0.024	0.024	0.024	0.024	0.024	0.024	0.024
Усны зарцуулалт	-	1,263	1,066	1,311	1,311	2,684	2,948	2,260	3,337	3,229	3,064	1,510	928	24,000
879,528 ТОНН ЧУЛУУЦАР ҮЙЛДВЭР.ТЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ														
Эргэл зуух ажиглалт хонго	31	29	25	6	31	30	31	31	30	15	30	31	31	320
Хувиарийн хонго	31	29	31	20	31	30	31	31	30	31	30	31	31	366
Зөгсөл хонго	0	0	6	24	0	0	0	0	0	16	0	0	0	46
Дундаж зүчин чадал, тн цаг /ольмоор/	172	172	183	183	183	183	183	183	183	183	172	172	172	172
Суурагдасан зүчин чадал	195	195	195	195	195	195	195	195	195	195	195	195	195	195
Хувиарийн дундаж зүчин чадал	88%	88%	94%	94%	94%	94%	94%	94%	94%	94%	88%	88%	88%	88%
Цагийн дундаж зүчин чадал тн цаг	110.3	110.3	117.1	117.1	117.1	117.1	117.1	117.1	117.1	117.1	117.1	110.3	110.3	110.3
Холын	1.56	1.56	1.56	1.56	1.56	1.56	1.56	1.56	1.56	1.56	1.56	1.56	1.56	1.56
Хонгогийн дундаж зүчин чадал	2,646	2,646	2,811	2,811	2,811	2,811	2,811	2,811	2,811	2,811	2,646	2,646	2,646	2,646
Чулуунсар	82,031	76,738	70,269	16,865	87,134	84,323	87,134	84,323	87,134	42,162	79,385	82,031	82,031	879,528
Усны норм	0.064	0.074	0.074	0.087	0.110	0.110	0.091	0.091	0.087	0.074	0.074	0.074	0.064	0.064
Усны зарцуулалт	5,250	5,679	5,200	1,467	10,108	9,276	7,929	7,929	7,336	3,120	5,874	5,250	5,250	5,250
Үйлдвэрийн нийт усны зарцуулалт	5,250	6,942	6,266	3,178	12,792	12,224	10,190	11,266	10,565	6,184	7,384	6,178	6,178	98,418
Угил ачуу усны норм	86.60	86.60	86.60	86.60	86.60	86.60	86.60	86.60	86.60	86.60	86.60	86.60	86.60	86.60
Угил ачуу усны зарцуулалт	2,685	2,511	2,165	320	2,685	2,598	2,685	2,598	2,598	1,299	2,598	2,598	2,598	2,685
Уурайга усны норм	15.25	15.25	45.53	64.70	100.33	100.33	64.70	64.70	64.70	45.53	45.53	45.53	45.53	15.25
Уурайга усны зарцуулалт	473	442	1,138	388	3,110	3,010	2,006	2,006	1,941	683	1,366	473	473	473
Ногоон байгууламжийн усны норм	-	-	-	143.24	174.54	174.54	168.95	168.95	143.24	36.17	-	-	-	-

Зураг 16. Цэвэршүүлэх байгууламжаас гарч буй илүүдэл усыг усалгаанд ашигласан зарцуулалт

Шугам сүлжээний гэмтлийг засварлах, усны алдагдал бууруулах:

Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний засвар үйлчилгээг тухай бүрд гүйцэтгэн ажилласан. Мөн ус хэмнэх зорилгоор ногоон байгууламжийн усалгаанд сүүлийн үеийн дуслын усалгааны системүүдээр ханган ажиллаж байна.





Зураг 17. Шугам сүлжээний засвар, угсралтын ажил гүйцэтгэж байгаа нь



Зураг 18. Хур тунадасны ус зайлуулж ногоон байгууламжинд ашиглах

Хаягдал усны гэрээ байгуулж, төлбөрийг цаг тухайд нь барагдуулах

“Ус бохирдуулсны төлбөрийн тухай” хуулийн дагуу бохир усыг хүрээлэн буй орчинд болон төвлөрсөн бохир усны шугаманд “Хүрээлэн байгаа орчин, Усны чанар, хаягдал усны ерөнхий шаардлага MNS4943:2015”, “Хүрээлэн байгаа орчин чанар, Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус, ерөнхий шаардлага MNS6561:2015” стандартаар тогтоосон норматив шаардлагад нийцүүлэн хаях зайлуулах зөвшөөрлийг нэг жилийн хугацаатайгаар авч гэрээг байгуулав.



Зураг 19. Хаягдал усны зөвшөөрөл, дүгнэлт

Ахуйн бохир ус, хатуу хаягдлаас урсац хөрсөнд алдагдахаас сэргийлэх, асгарсан тохиолдолд бохирдсон байдлаас шалтгаалан саармагжуулах, цэвэрлэх арга хэмжээ авах

Тайлант онд үйлдвэрийн бохир ус цэвэрлэх байгууламжинд тогтмол үзлэг шалгалт хийж ажилласан мөн Хаанзаа ХХК гэрээ байгуулж зөвлөх үйлчилгээ авч ажиллаж байна.



Зураг 20. “Хаанзаа” ХХК зөвлөх үйлчилгээ үзүүлж буй нь

Шатах тослох материалыг битүүмжлэлтэй саванд хадгалах

Үйлдвэрийн шатахуун түгээх станц 2024 онд шинээр байгуулагдсан бөгөөд түлшний машинаас техникүүдэд түлш олголт хийгддэг. Ашигласан тос маслыг зориулалтын саванд цуглуулж үйлдвэрийн үйл ажиллагаанд дахин ашиглаж байна.



Зураг 21. ШТС



Зураг 22. Түлшний машин болон ашигласан тос цуглуулах хэсэг

Тосны асгаралтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах

Асгаралтаас урьдчилан сэргийлэх, асгаралт үүссэн үед бэлэн байдлыг хангах зорилгоор асгаралт үүсгэх эрсдэлтэй цэгүүдийг тодорхойлж тус цэгүүд дээр асгаралтын үед хэрэглэх багаж хэрэгсэл, сав зэргийг байрлуулан хаягжуулсан. Үйлдвэрийн талбайд бохирдсон хөрсийг саармагжуулах цэг байгуулах төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Мөн сар бүр ажлын байрны үзлэг хийж гарсан асгаралтуудыг журмын дагуу цэвэрлүүлж, хариу арга хэмжээг авч ажиллаж байна.



Зураг 23. Асгаралтын хариу арга хэмжээ үйлчилгээний талбайг цэвэрлүүлсэн байдал



